



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“ОСТТ” хязгаарлагдмал хариуцлагатай компаниас төрийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлсэн 10 нэрийн, нийт 22,170,000.00 (хорин хоёр сая нэг зуун далан мянган) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Тавинбэх, “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал О.Төмөрхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.“ОСТТ” ХХК-ийн 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23/0208-01 дугаар албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу тус компанийн эзэмшлийн 2750 м.кв талбай бүхий газрыг үнэ төлбөргүй шилжүүлэн авах, үнэлж бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001025
5-phuraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 02 дугаар сарын-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



**"ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Ус нөөцлөх сав	ш	1	1,800,000.00	1,800,000.00
2	Ялтсан бойлер	ш	1	2,000,000.00	2,000,000.00
3	Цахилгааны шит 380V	ш	1	410,000.00	410,000.00
4	Шугам Ф-100мм труба	м	20	7,000.00	140,000.00
5	Шугам Ф-80мм труба	м	20	5,000.00	100,000.00
6	Шугам Ф-50мм труба	м	25	4,000.00	100,000.00
7	Эргэлтийн насос	ш	2	580,000.00	1,160,000.00
8	Дулаан дамжуулах төвийн байр	ш	1	9,660,000.00	9,660,000.00
9	Гадна 1-р контрын шугам Ф-159	м	32	100,000.00	3,200,000.00
10	Гадна 1-р контрын шугам Ф-100	м	45	80,000.00	3,600,000.00
					22,170,000.00
Нийт дүн					(хорин хоёр сая нэг зуун далан мянга)